

2025 華語獎學金徵選辦法

2025 оны Тайваний Боловсролын Яамны

Хятад хэлний тэтгэлэгт сонгон шалгаруулах журам

為增進台灣與蒙古雙邊文教合作，台灣教育部於 2025 年提供華語文獎學金供蒙古國人士在臺研習中文，每個月獎學金補助新台幣 28,000 元(約美金 850 元)，申請人須自付來回機票、當地交通、住宿及華語中心學費。本獎學金將先交付各華語中心，再轉交受獎人領用。

Монгол, Тайвань хоёр орны соёл, боловсролын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх зорилгоор Тайваний боловсролын яамнаас Монгол улсын иргэншилтэй хэн бүхэнд энэ 2025 онд хятад хэлний тэтгэлэг олгохоор боллоо. Тус тэтгэлэгт **сар бүр 28,000 шинэ тайвань доллар /NTD/ (ойролцоогоор 850 орчим ам.доллар)** олгох бөгөөд тэтгэлэгт өргөдөл гаргагч нь хоёр талын онгоцны тийз болон Тайваньд байрлах хугацаан дахь байр, унааны зардал, сургалтын төлбөр зэргийг өөрөө хариуцна. Тэтгэлгийг шууд Хятад хэлний төв (Chinese Language Center)-д нь олгох бөгөөд сургалтын төвөөрөө дамжуулан тэтгэлгээ авна.

申請資格 Тэтгэлэг хүсэгчид тавигдах шаардлага:

18 歲以上具高級中等以上學校畢業學歷，學業成績優良，品行端正之蒙古籍人士。具下列資格者不得申請：

18-аас дээш насны, бүрэн дунд болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, онц сайн дүнтэй, сахилга бат сайтай Монгол улсын иргэншилтэй байх бөгөөд доорх нөхцөлд тэтгэлэгт бүртгүүлэх боломжгүй. Үүнд:

1. 具僑生身分或持中華民國護照者。

Хилийн чанад дахь Тайвань иргэн эсвэл Тайвань паспорт эзэмшигч.

2. 現已在台研習華語文或曾在台修讀學位課程。

Тайваньд хятад хэл сурч байсан эсвэл Тайваньд эрдмийн зэргээр суралцаж байсан оюутан.

3. 曾領取本獎學金或台灣獎學金。

Тус тэтгэлэгт хөтөлбөрт болон Тайваний боловсролын яамны тэтгэлэгт хамрагдаж байсан оюутан.

4. 在台研習期間同時為我各大學院校依據與外國學校簽訂學術合作協議所招收之交換學生。

Хэлний бэлтгэлд сууж байх үедээ Тайваний их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний шугамаар солилцооны оюутанаар суралцах.

5. 同時領受我政府機關或學校所設置之獎補助金。

Оюутан давхар Тайваний төрийн байгууллагуудын зарласан эсвэл сургуулийн тэтгэлэгт зэрэг бүртгүүлсэн тохиолдолд уг тэтгэлэгт бүртгүүлэх боломжгүй.

獎學金時間及類別 Тэтгэлгийн хугацаа болон төрөл:

A	暑 Зуны анги 2025 JUN~2025 JUL
B	暑 Зуны анги 2025 JUL~ 2025 AUG
C	2025 SEP~2025 NOV
D	2025 DEC~2026 FEB
E	2026 MAR~ 2026 MAY
F	2026 JUN~ 2026 AUG

應備文件 Бүрдүүлэх материал:

申請人請於本年 4 月 30 日(上班日 9:00-12:00)之前至本處遞交下列文件。本處將於 2025 年 7 月底前公布正取候選人名單。

Тэтгэлэгт хүсэлт гаргагч нь 2025 оны 4-р сарын 30-ний өдөр хүртэл (**Ажлын өдрүүдэд 09:00-12:00 цагийн хооронд**) дор дурдсан материалыг манай Төлөөлөгчийн газарт бүрдүүлж өгөх ба тэтгэлэгт урьдчилсан байдлаар тэнцсэн хүмүүсийн нэрсийг 2025 оны 7-р сарын сүүлээр зарлана.

1. 工作單位負責人或就讀學校校長/老師之推薦函正本
Ажил эрхэлж буй байгууллагын удирдлага эсвэл сурч буй сургуулийн захирал/багшийн тодорхойлсон захидал **ЭХ ХҮВЬ**
2. 申請人已填妥之獎學金申請表
Өргөдөл гаргагчийн бөглөсөн тэтгэлгийн өргөдлийн маягт
3. 已簽署之教育部華語文獎學金承諾書
Өргөдөл гаргагчийн гарын үсэг зурж баталгаажуулсан Тайваний боловсролын яамны хятад хэлний тэтгэлгийн амлалтын бичиг
4. 申請人護照影本
Өргөдөл гаргагчийн гадаад паспортын хуулбар
5. 高中以上最高學歷證書及成績單影本
Бүрэн дунд болон түүнээс дээш эрдмийн зэргийн диплом болон дүнгийн хуудасны **хуулбар**
6. 台灣國內華語中心入學許可影本
Тайваний хятад хэлний сургалтын төв (Chinese Language Center)-өөс ирүүлсэн урилга **хуулбар**
7. 財力證明至少約美金 3,000 元。
Санхүүгийн баталгаа доод тал нь **10-11 сая төгрөгийн үлдэгдэлтэй тодорхойлолт.**

檢附申請表、承諾書及台灣華語教學機構一覽表，敬請參考。

Тэтгэлгийн өргөдлийн маягт, амлалтын бичиг болон Тайваний хятад хэлний сургалтын төвүүдийн жагсаалтыг хавсаргав.

- [申請表 \(Application Form\).doc](#)
- [申請表 \(Application Form\).pdf](#)
- [承諾書 Амлалтын бичиг \(Agreement\)](#)
- [台灣華語教學機構一覽表 Тайвань дахь Хятад сургалтын төвүүдийн жагсаалт. \(School List\)](#)

收件處：駐烏蘭巴托台北貿易經濟代表處

3F, Taiwan Center, Tourist Street No.38, Chingeltei District, Ulaanbaatar-13, Mongolia.

Tel : +976-11-322735

Материал хүлээн авах газар:

Тайпэйн Худалдаа, Эдийн засгийн Улаанбаатар дахь Төлөөлөгчийн газар

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот-13, Чингэлтэй дүүрэг, Ш/Х-1269, Жуулчны гудамж-38, Урт цагаан, Тайваний төв 3 давхар

Холбоо барих: +976-11-322735

Цахим шуудан: tteromn@mofa.gov.tw